



 **ХБНГУ–ын
Улс төрийн намын
тухай хууль**

2020 оны 5-р сарын 22-ний өдрийн байдлаар

Монгол дахь Конрад-Аденауэр-Сан герман хэлнээс орчуулав.



Монгол дахь Конрад-Аденауэр-Сан
Сөүлийн гудамж Браухаус 22
Улаанбаатар хот 14253
Монгол улс

www.kas.mongolia
www.facebook.com/kas.mongolia
www.kas.edu.mn



Өмнөх үг

Эрхэм хүндэт хатагтай ноёдоо,
Конрад-Аденауэр-Сангийн түнш дэмжигчдээ,

Ардчилалсан нийгэмд намуудын оролцоо чухал ба ардчиллын тогтолцоог бат бэх ажиллагаатай байлгахад намууд олон төрлийн үүрэг гүйцэтгэдэг билээ. Герман улсад намуудын үйл ажиллагаа ямар эрх зүйн үндэс суурьтай, төр намуудын санхүүжилтэнд хэрхэн оролцож ирсэн вэ?

Энэхүү асуултын хариуг Герман улсын Намын тухай хууль өгдөг. Монгол хэл рүү хөрвүүлэн нийтэлж буй энэ хууль намтай холбогдох эрх зүйн нарийвчилсан зохицуулалтуудыг агуулна. Нэн тэргүүнд үндсэн хуулиар тогтоосон намуудын статус, чиг үүрэг, намын тухай ойлголт, намд оноох нэр, дотоод зохион байгуулалт болон төрөөс санхүүжилт олгох зарчим, түүний хэмжээ зэрэг асуудлыг тусгасан болно.

Намгүйгээр Холбооны Герман улсын улс төрийн тогтолцоог төсөөлөшгүй. Христийн Арчилсан Холбоо нам, Социал-демократ, Герман улсын сонголт, Чөлөөт демократ, Зүүний нам, Ногоон нам, Христийн нийгмийн холбоо зэрэг нийт долоон нам Бундестагт төлөөлөлтэй. Үүний зэрэгцээ олон тооны жижиг нам Европын Холбоо эсвэл 16 муж улсын парламентад сонгогчдынхоо эрх ашгийг төлөөлнө. Конрад Аденауэр Сан нь 15 гаруй жилийн турш Холбооны улсын Канцлераар сонгогдсон Ангела Меркель тэргүүтэй Христийн Ардчилсан Холбоо намд ойр улс төрийн сан билээ. Христийн Ардчилсан Холбоо христийн иргэний нийгмийг нэгтгэн төлөөлөх нам болж 1950 болж үүсгэн байгуулагдсан билээ. Үүнээс хойш энэ нам Герман улсын гадаад болон дотоод бодлогын үндсэн шийдвэрүүдийг гаргахад төр барих намын хувьд голлон оролцсон юм.

Германулсын түүхэнд нийгэм дэх зөрчлүүдийг тайван замаар зохицуулахад улс төрийн намууд чухал байр суурьтай оролцож ирсэн ба улмаар Герман улс дахь ардчиллын найдвартай баталгаа нь болж чадсан. Ялангуяа төрөөс намуудыг санхүүжүүлэх асуудал Монгол улсад дахин дахин хэлэлцэх сэдэв болдог. Герман улсын эрх зүйн зохицуулалтыг орчуулснаар Монголд өрнөж буй мэтгэлзээнд сонирхолтой түлхэц өгнө гэдэгт найдаж байна.

*Йоханн Фурманн,
Конрад Аденауэр Сангийн суурин төлөөлөгч
2020 оны 12-р сар*

АГУУЛГА

Өмнөх үг
УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ (Намын тухай хууль)
Тэмдэглэл

Нэгдүгээр бүлэг

Нийтлэг зүйл

1-р зүйл. Үндсэн хуулиар тогтоосон намын эрх зүйн байдал болон чиг үүрэг

2-р зүйл. Намын тухай ойлголт

Тэмдэглэл

3-р зүйл. Эрх зүйн чадамж

4-р зүйл. Нэр

5-р зүйл. Эрх тэгш хандах

Хоёрдугаар бүлэг

Дотоод зохион байгуулалт

6-р зүйл. Намын дүрэм, мөрийн хөтөлбөр

7-р зүйл. Бүтэц, зохион байгуулалт

8-р зүйл. Намын дээд байгууллага

9-р зүйл. Гишүүдийн хурал, төлөөлөгчдийн хурал (намын их хурал, бүгд хурал)

10-р зүйл. Гишүүдийн эрх

11-р зүйл. Удирдах зөвлөл

12-р зүйл. Намын хороо

13-р зүйл. Төлөөлөгчдийн хурлын бүрэлдэхүүн

14-р зүйл. Намын хяналтын хороо

15-р зүйл. Намын дээд байгууллага тогтоол гаргах үйл явц

16-р зүйл. Намын орон нутгийн байгууллагад ногдуулах арга хэмжээ

Гуравдугаар бүлэг

Сонгуульд нэр дэвшүүлэх

17-р зүйл. Сонгуульд нэр дэвшүүлэх

Дөрөвдүгээр бүлэг

Төрөөс санхүүжүүлэх

18-р зүйл. Төрөөс санхүүжүүлэх зарчмууд ба санхүүжилтийн хэмжээ

19-р зүйл. Төрийн санхүүжилт авах тухай өргөдөл гаргах

19а зүйл. Санхүүжилтийн хэмжээг тогтоох ажиллагаа

Тэмдэглэл

20-р зүйл. Хэсэгчилсэн санхүүжилт

21-р зүйл. Төсвөөс хөрөнгө гаргах ба Төрийн аудитын хороогоор шалгуулах

22-р зүйл. Намын дотоод санхүүгийн зохицуулалт

Тавдугаар бүлэг**Тайлагнах**

- 23-р зүйл. Нийтэд тайлагнах үүрэг
- 23а зүйл. Тайланг нягтлан шалгах
- 23б зүйл. Тайлангийн алдаа, зөрчлийг мэдүүлэх үүрэг
- 24-р зүйл. Тайлан
- 25-р зүйл. Хандив
- Тэмдэглэл
- 26-р зүйл. Орлогын тухай ойлголт
- 26а зүйл. Зарлагын тухай ойлголт
- 27-р зүйл. Орлогын тодорхой төрлүүд
- 28-р зүйл. Өмч хөрөнгийн баланс
- 29-р зүйл. Тайланг хянан шалгах
- 30-р зүйл. Шалгалтын тайлан, тэмдэглэл
- 31-р зүйл. Аудитор

Зургаадугаар бүлэг**Тайланг буруу гаргасан тохиолдолд авах арга хэмжээ болон хариуцлагын заалтууд**

- 31а зүйл. Төрөөс олгосон санхүүжилтийг буцааж төлөх
- 31б зүйл. Тайлангийн алдаа
- 31в зүйл. Хууль бусаар олж авсан эсвэл ил болгоогүй хандив
- 31-р зүйл. Эрүүгийн хариуцлагын заалтууд

Долоодугаар бүлэг**Үндсэн хуульд харш намыг хориглох**

- 32-р зүйл. Хориглох шийдвэрийг гүйцэтгэх
- 33-р зүйл. Орлох байгууллагыг хориглох

Наймдугаар бүлэг.**Төгсгөлийн заалтууд**

- 34-р зүйл. (Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн өөрчлөлт)
- 35-р зүйл. (Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуулийн өөрчлөлт)
- 36-р зүйл. (Татварын хууль тогтоомжийг хэрэглэх тухай)
- 37-р зүйл. Иргэний хуулийн нэг заалтыг хэрэглэхгүй байх тухай
- 38-р зүйл. Албадлагын хэрэгсэл
- 39-р зүйл. Төгсгөл болон шилжилтийн зохицуулалт
- 40-р зүйл. (Хүчингүй болсон)
- 41-р зүйл. (Хүчин төгөлдөр болох)

Герман хэлнээс орчуулав

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ (Намын тухай хууль)

PartG

Албажуулсан огноо: 1967 оны 07 сарын 24

Бүтэн нэр:

“Намын тухай хууль” (BGBl. I S. 149), 1994 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр нийтлэгдсэн найруулга, 1967 оны 07 сарын 24 хамгийн сүүлд 2020 оны 8 дугаар сарын 19-ны тогтоолын 13-р зүйлийн дагуу өөрчлөлт орсон (BGBl. I S. 1328)”

Төлөв байдал: 1994 оны 1-р сарын 31-нд шинэчилсэн найруулгыг нийтэлсэн I 149;
хамгийн сүүлд 2020 оны 6-р сарын 19-ны тогтоолын 13-р зүйлээр өөрчлөлт орсон I 1328

Тэмдэглэл

(+++ Текстын хүчинтэй хугацаа: 1974 оны 7-р сарын 28-ны өдрөөс эхлэн +++)

(+++ Хэрэглэхэд 39-р зүйлийн 5-р хэсгийг харьцуулах +++)

(+++ Нэгдэх тухай гэрээний заалтуудыг цаашид хэрэглэхгүй, Намын тухай хуулийн “Нэгдэх гэрээ” хавсралтыг харьцуулах +++)



НИЙТЛЭГ ЗҮЙЛ

БҮЛЭГ

1-р зүйл. Үндсэн хуулиар тогтоосон намын эрх зүйн байдал болон чиг үүрэг

- (1) Нам нь үндсэн хуулиар тогтоосон чөлөөт ардчилсан эрх зүйн зайлшгүй шаардлагатай бүрэлдэхүүн хэсэг юм. Ард түмний улс төрийн хүсэл зоригийг бүрдүүлэхэд нам тогтмол, чөлөөтэй оролцож, улмаар үндсэн хуулиар баталсан болон ногдуулсан нийтийн чиг үүргээ биелүүлнэ.
- (2) Ард түмний улс төрийн хүсэл зоригийг бүрдүүлэхэд нам нийгэм-улс төрийн амьдралын салбар бүрт оролцох ба ялангуяа нийгэм дэх үзэл бодолд нөлөөлөх, улс төрийн боловсролыг гүнзгийрүүлэх, иргэдийн улс төрийн амьдралд оролцох идэвхийг хөхиүлэн дэмжих, нийтийн хариуцлагатай алба хаших чадвартай иргэдийг бэлтгэх, Холбооны улс болон орон нутгийн сонгуульд оролцож нэр дэвшүүлэх, парламент ба засгийн газрын ажилд улс төрийн нөлөө үзүүлэх, улс төрийн зорилт, мөрийн хөтөлбөрөө төрийн шийдвэрт тусгуулах, төр ба ард түмнийг холбоог тасралтгүй нягт байлгахыг зорино.
- (3) Нам өөрийн зорилтуудыг мөрийн хөтөлбөртөө тусгана.
- (4) Нам өөрийн хөрөнгөө гагцхүү үндсэн хууль болон энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулна.

2-р зүйл. Намын тухай ойлголт

- (1) Нам нь иргэдийн эвлэлдэн нэгдсэн холбоо бөгөөд ард түмний хүсэл зоригийг бүрдүүлэх ажиллагаанд тогтмол буюу урт хугацаанд нөлөөлж, Холбооны улс болон мужулсын парламентад ард түмнийг төлөөлөхийг эрмэлзэхийн зэрэгцээ энэхүү эрмэлзлээ хэрэгжүүлэх түүний чадвар нь зохион байгуулалтын цар хүрээ, бат бөх байдал, гишүүдийн тоо, олон нийтэд өөрийгөө илэрхийлэн таниулсан байдал зэрэг бодит ерөнхий нөхцлүүдээр нотлогдох ёстой. Намын гишүүн гагцхүү хувь хүн байж болно.
- (2) Бундестагийн эсвэл муж улсын парламентын сонгуульд 6 жилийн турш нэр дэвшүүлэн оролцоогүй улс төрийн холбоо намын эрх зүйн байдлаа алдана. Мөн 23-р зүйлийн дагуу нийтэд тайлагнах үүргээ зөрчин 6 жил дараалан нийтэд тайлагнаагүй улс төрийн холбоонд энэ заалт мөн адил үйлчилнэ. 19а зүйлийн 3-р хэсгийн 5-р өгүүлбэр зохих ёсоор үйлчилнэ.
- (3) Дараах улс төрийн холбоог намд тооцохгүй:
 1. гишүүдийн олонхи эсвэл удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи нь гадаад улсын иргэн байх буюу
 2. төв байгууллага эсвэл удирдлага нь энэ хуулийн үйлчлэх нутаг дэвсгэрийн гадна байрлах бол.

Тэмдэглэл

(+++ 2-р зүйлийн 2-р хэсгийн 2-р өгүүлбэр: Хэрэглэхэд 39-р зүйл, 5-р хэсэг 1-р өгүүлбэрийг харьцуулах +++)

3-р зүйл. Эрх зүйн чадамж

Нам нь өөрийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах, эсвэл хариуцагч байх эрх үүрэгтэй. Намын дүрэмд өөрөөр заагаагүй бол намын орон нутгийн дээд түвшний байгууллага энэ эрх үүргийг эдэлнэ.

4-р зүйл. Нэр

- (1) Улс төрийн намын нэр өмнө нь байгуулагдсан бусад намын нэрнээс тод ялгаатай байх шаардлагатай. Намын товчилсон нэр мөн дээрхи шаардлагыг хангана. Сонгуулийн сурталчилгаа болон бусад сонгуулийн үйл ажиллагаанд гагцхүү намын дүрэмд заасан нэрийн товчлолыг хэрэглэнэ. Нэмэлт тодруулга бүхий өөр нэрийг хэрэглэх албагүй.

- (2) Намын орон нутгийн байгууллага намынхаа нэр дээр тухайн орон нутгийг заасан тодотголыг хэрэглэж болно. Тодотголыг намын нэрийн дараа байрлуулна. Ердийн сурталчилгаа болон сонгуулийн сурталчилгаанд энэхүү нэмэлт тодотголыг орхиж болно.
- (3) Намаа орхиж гарсан орон нутгийн байгууллага намын нэрийг ашиглах эрхгүй. Хуучин нэр дээр нэмэлт тодотгол оруулж шинээр нэр оноохгүй. Товчилсон нэр мөн дээрхи шаардлагыг хангана.

5-р зүйл. Эрх тэгш хандах

- (1) Нийтийн албаны эрх мэдэл бүхий албан тушаалтан намуудад барилга байгууламж хэрэглүүлэх эсвэл нийтийн бусад үйлчилгээг үзүүлэх бол намуудыг хооронд нь ялгаварлан гадуурхаж болохгүй. Үзүүлэх тусламж, үйлчилгээний хэмжээг намуудын ач холбогдлоор эрэмблэн, тухайн нам зорилгоо хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэгийн доод хэмжээг тогтоож болно. Намуудын ач холбогдолыг тогтоохдоо нэн тэргүүнд бүх түвшний иргэдийн хурлын төлөөлөгчдийн хурлын сүүлийн сонгуульд авсан саналын хувь хэмжээг баримтлана. Бундестагт намын бүлэг байгуулах хэмжээний суудал авсан намд үзүүлэх дэмжлэг үйлчилгээний хэмжээ аль нэг өөр намд үзүүлэх дэмжлэгийн талаас багагүй байна.
- (2) Сонгуультай холбогдон төрөөс дэмжлэг үзүүлэхэд энэ зүйлийн 1-р хэсэг үйлчлэх ба энэ нь гагцхүү сонгуульд нэр дэвшүүлж буй намд хамаарна.
- (3) Энэ зүйлийн 1-р хэсэгт заасан төрийн дэмжлэгийг үзүүлэхэд нам бүрт адил үйлчлэх тодорхой нөхцөл, болзол тавьж болно.
- (4) Энэ хуулийн 4-р бүлгийн үйлчлэл хэвээр байна.

2

ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

БҮЛЭГ

6-р зүйл. Намын дүрэм, мөрийн хөтөлбөр

- (1) Нам бичгээр үйлдсэн дүрэм болон мөрийн хөтөлбөртөй байна. Намын дээд шатны байгууллагын дүрэмд өөрөөр заагаагүй бол намын орон нутгийн нэгж асуудлаа мөн өөрийн дүрмээр зохицуулна.
- (2) Намын дүрэмд дараах зүйлийг заавал тусгана:
 1. намын нэр, хэрэглэх шаардлагатай бол товч нэр, намын байрлах хаяг, үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр,
 2. гишүүнээр элсүүлэх, гишүүнээс гарах журам,
 3. гишүүний эрх, үүрэг,
 4. гишүүнд ногдуулах сахилгын арга хэмжээ, гишүүнээс хасах (10-р зүйлийн 3-5),
 5. орон нутгийн байгууллагад ногдуулах сахилгын арга хэмжээ,
 6. намын ерөнхий бүтэц, зохион байгуулалт,
 7. удирдах зөвлөл болон бусад дээд байгууллагын бүрэлдэхүүн, бүрэн эрх,
 8. энэ хуулийн 9-р зүйлийн дагуу зөвхөн нийт гишүүдийн болон төлөөлөгчдийн их хурлаар шийдвэрлэх асуудал,
 9. нийт гишүүд, төлөөлөгчдийн хурлыг зарлан хуралдуулах нөхцөл, хэлбэр, хугацаа, шийдвэрүүдийн албажуулалт,
 10. хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшүүлэх эрх бүхий орон нутгийн намын байгууллага болон дээд байгууллага,
 11. энэ хуулийн 9-р зүйлийн 3-р хэсэгт заасны дагуу намын их хурлаас намыг буюу орон нутгийн намын байгууллагыг татан буулгах тухай, эсвэл өөр

намтай нэгдэх тухай тогтоолын талаар нийт гишүүдийн санал хураалт явуулах журам. Нийт гишүүдийн санал хураалтын үр дүнгээр тогтоолыг баталгаажуулсан, өөрчлөгдсөн эсвэл хүчингүй болсонд тооцно,

12. Энэ хуулийн 5-р бүлгийн заалтуудын шаардлагыг хангасан намын санхүүгийн журам, түүний хэлбэр, агуулга.

7-р зүйл. Бүтэц, зохион байгуулалт

- (1) Нам орон нутгийн байгууллагуудтай байна. Энэ нэгж байгууллагын хэмжээ, цар хүрээг намын дүрмээр зохицуулна. Намын орон нутгийн зохион байгуулалт нь намын жирийн гишүүдэд намын шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг бүрдүүлж өгсөн байх учиртай. Зөвхөн муж улсын статустай нэг хотын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулах бол нам орон нутгийн нэгж байгуулах албагүй, ийм байгууллагыг энэ хуулийн дагуу намд тооцно. Намын ерөнхий бүтцэд саад учруулахгүйгээр намын орон нутгийн хэд хэдэн байгууллагыг зохион байгуулалтын шаардлагаар нэгтгэж болно.
- (2) Муж улсын намын байгууллагагүй намын хувьд энэ хуулийн муж улсын намын байгууллагад холбогдох заалтууд тус намын харьяа доод шатны орон нутгийн байгууллагад үйлчилнэ.

8-р зүйл. Намын дээд байгууллага

- (1) Гишүүдийн хурал, намын удирдах зөвлөл нь нам болон намын орон нутгийн байгууллагад заавал байх шаардлагатай дээд байгууллагууд юм. Нэгээс илүү сууринг хамрах намын байгууллагын нийт гишүүдийн хурлыг төлөөлөгчдийн хурал орлохыг намын дүрмээр зохицуулж болно. Энэ хуралд суух төлөөлөгчдийг 2 жил хүртэл хугацаагаар доод шатны үүрүүдийн хурлаар сонгоно. 7-р зүйлийн 1-р хэсгийн 4-р өгүүлбэрт дурдсан орон нутгийн байгууллагагүй муж улсын нам нь 250-иас илүү гишүүнтэй бол гишүүдийн хурлын оронд төлөөлөгчдийн хурлыг хийж болно. Орон нутгийн анхан шатны нэгж 250 –иас илүү гишүүнтэй эсвэл томоохон нутаг дэвсгэрийг хамрах бол мөн гишүүдийн хурлыг төлөөлөгчдийн хурлаар орлуулж болно.
- (2) Намын дүрэмд орон нутгийн намын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх бусад бүтэц, дээд байгууллагыг тусгаж болно. Намын дүрэмд эдгээрийн чиг үүргийг тодорхой заана.

9-р зүйл. Гишүүдийн хурал, төлөөлөгчдийн хурал (намын их хурал, бүгд хурал)

- (1) Гишүүдийн эсвэл төлөөлөгчдийн хурал (намын их хурал, бүгд хурал) нь

намын орон нутгийн байгууллагын эрх барих дээд байгууллага мөн. Энэ хурлыг намын орон нутгийн дээд түвшний нэгжийн хувьд намын “их хурал” гэж нэрлэх бөгөөд доод түвшний орон нутгийн нэгжийн хувьд “бүгд хурал” гэж нэрлэнэ. Намын их хурлыг зохицуулсан энэ хуулийн дараах заалтууд “бүгд хурал”-д мөн адил үйлчилнэ. Намын их хурлыг хоёр жил тутамд нэгээс доошгүй удаа хуралдуулна.

- (2) Намын дүрэмд орон нутгийн намын удирдах зөвлөл болон бусад дээд байгууллагын гишүүдийг, мөн энэ хуулийн 11-р зүйлийн 2-д заасан хүнийг төлөөлөгчдийн хуралд гишүүнээр шууд оруулах тухай зааж болох ба эдгээрийн нийт тоо нь дүрэмд тусгагдсан нийт саналын эрхтэй төлөөлөгчдийн тавны нэгээс хэтрэх ёсгүй.
- (3) Намын орон нутгийн байгууллага өөрийн эрх мэдлийн хүрээнд их хурлаараа намын мөрийн хөтөлбөр, дүрэм, татварын журам, хяналтын хорооны журам, намыг татан буулгах, өөр намтай нэгдэх тухай тогтоол гаргана.
- (4) Энэ хуульд өөрөөр заагаагүй бол намын их хурлаас орон нутгийн намын дарга, түүний орлогч, удирдах зөвлөл болон бусад дээд байгууллагын гишүүн болон намын дээд шатны байгууллагад томилогдох төлөөлөгчдийг сонгоно.
- (5) Намын их хурал хоёр жил тутамд нэгээс доошгүй удаа удирдах зөвлөлийн тайланг авч хэлэлцэж, тайлангийн талаар тогтоол гаргана. Тайлангийн санхүүгийн хэсгийг тайлан тавихаас өмнө их хурлаас сонгосон аудитын хянан шалгагчаар шалгуулна.

10-р зүйл. Гишүүдийн эрх

- (1) Намын дүрэмд тодорхой заасан журмын дагуу намын эрх бүхий дээд байгууллага намд гишүүдийг элсүүлэн авна. Намд элсэх өргөдөлд татгалзсан шийдвэрт үндэслэл заах албагүй. Намд элсүүлэхгүй гэсэн ерөнхий болон хугацаатай хориг байх ёсгүй. Сонгох, сонгогдох эрхээ шүүгчийн шийдвэрийн дагуу хасуулсан этгээд намын гишүүн байж болохгүй.
- (2) Намын гишүүд болон намын дээд байгууллагад төлөөлөгчөөр сонгогдсон гишүүд санал өгөх тэгш эрхтэй байна. Гишүүний татвараа төлсөн эсэхээс шалтгаалан санал өгөх эрхийг эдлэх тухай намын дүрэмд нарийвчлан зохицуулж болно. Гишүүн хэзээ ч намаас гарах эрхтэй.
- (3) Намын дүрэмд дараах асуудлыг тусгасан байна:
 1. Гишүүдэд хүлээлгэх сахилгын арга хэмжээ,
 2. Сахилгын арга хэмжээ авах үндэслэл болох нөхцөл байдал,
 3. Сахилгын арга хэмжээ авах эрх бүхий намын дээд байгууллага.

Намын албан тушаалаас огцруулах эсвэл эдгээр албан тушаалыг хаших чадваргүй гэж үзсэн тогтоолд үндэслэлийг заавал тусгана.

- (4) Намын дүрмийг санаатай зөрчсөн, эсвэл намын зарчим, журмыг ноцтой зөрчиж энэ үйлдлээрээ намд хүнд хохирол учруулсан тохиолдолд л тухайн гишүүнийг намын гишүүнээс хасаж болно.
- (5) Намын гишүүнээс хасах асуудлыг намын хяналтын журмын дагуу хариуцах намын хяналтын хороо шийдвэрлэнэ. Намын дээд шатны хяналтын хороонд энэ асуудлаар давж заалдах эрх нээлттэй байна. Шийдвэрүүдийн үндэслэлийг бичгээр гаргана. Яаралтай буюу ноцтой тохиолдолд намын эсвэл намын орон нутгийн байгууллагын удирдах зөвлөл нь намын хяналтын хороо асуудлыг шийдвэрлэх хүртэл тухайн гишүүнийн эрхийг түдгэлзүүлж болно.

11-р зүйл. Удирдах зөвлөл

- (1) Удирдах зөвлөлийг хоёр жилээс хэтрэхгүй хугацаанд шинээр сонгоно. Удирдах зөвлөл гурваас багагүй гишүүнээс бүрдэнэ.
- (2) Сонгуулийн үр дүнгээр сонгуульт ажил, албан тушаалд томилогдсон намын гишүүнийг намын дүрмийн зохицуулалтаар удирдах зөвлөлд шууд оруулж болно. Энэ хуулийн 9-р зүйлийн 4-д зааснаас өөр журмаар удирдах зөвлөлд орох гишүүдийн тоо удирдах зөвлөлийн нийт гишүүдийн тавны нэгээс хэтэрч үл болно. Намын дарга болон намын санхүүгийн албаны дарга намын дэргэдэх улс төрийн санд адил төстэй албыг давхар хашиж болохгүй.
- (3) Намын орон нутгийн байгууллагын удирдах зөвлөл тус орон нутгийн намын ажлыг хууль, намын дүрэм, дээд шатны намын байгууллагын тогтоолуудыг мөрдөн удирдана. Намын дүрэмд өөрөөр заагаагүй бол удирдах зөвлөл орон нутгийн намыг Иргэний хуулийн 26-р зүйлийн 1-ийн 2,3-р өгүүлбэрт заасны дагуу төлөөлнө.
- (4) Удирдах зөвлөлийн тогтоолуудыг хэрэгжүүлэх, түүнчлэн удирдах зөвлөлийн өдөр тутмын болон яаралтай ажил үүргийг гүйцэтгэх зорилгоор удирдах зөвлөлийн гишүүд дотроос удирдах зөвлөлийн тэргүүлэгчдийг бүрдүүлж болно. Тэргүүлэгчдийг удирдах зөвлөлөөс сонгох, эсвэл намын дүрэмд зааснаар томилж болно.

12-р зүйл. Намын хороо

- (1) Намын дүрмийн дагуу улс төр, зохион байгуулалтын асуудлаар зөвлөх, шийдвэр гаргах бүрэн эрхтэй намын хороо болон тэдгээртэй дүйцэх

байгууллагын гишүүдийг намын доод шатны орон нутгийн байгууллагаас сонгож болно.

- (2) Удирдах зөвлөл болон энэ хуулийн 11-р зүйлийн 2-д нэр заасан нэр бүхий гишүүд намын хороонд дүрмийн дагуу шууд орж болно. Сонгогдоогүй орж ирэх гишүүдийн тоо намын хорооны нийт гишүүдийн гуравны нэгээс хэтэрч болохгүй. Хороонд зөвхөн зөвлөх эрхтэй гишүүдийг нэмж элсүүлэн авч болох боловч бүх сонгогдоогүй орж ирсэн гишүүдийн тоо хорооны нийт гишүүдийн талаас илүүгүй байна.
- (3) Энэ зүйлийн 1-д дурдсан дээд байгууллагад гишүүнээр сонгогдон ажиллах хугацаа 2 жилээс илүүгүй байна.

13-р зүйл. Төлөөлөгчдийн хурлын бүрэлдэхүүн

Төлөөлөгчдийнхуралболонданбуюухэсэгчлэннамынороннутгийнбайгууллагын төлөөлөгчдөөс бүрдэх намын дээд байгууллагын бүрэлдэхүүнийг намын дүрмээр зохицуулна. Намын орон нутгийн байгууллагыг төлөөлөх гишүүдийн тоог тогтоохдоо тус орон нутгийн байгууллагад харьяалагдах нийт гишүүдийн тоог голлон харгалзана. Үүний зэрэгцээ намын дүрэмд нийт төлөөлөгчдийн тал хувьд хүрэхгүй хэсгийг тухайн орон нутгийн намын өөрийн нутаг дэвсгэрт сүүлд явагдсан иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд авсан сонгогчдын саналын тоонд хувь тэнцүүлэн орон нутгийн нам тус бүрт төлөөлөгчдийн тоог тогтооно. Санал өгөх эрхийг эдлэх асуудлыг тухайн орон нутгийн байгууллага татвар төлөх үүргээ хэрхэн биелүүлсэнтэй холбож болно.

14-р зүйл. Намын хяналтын хороо

- (1) Намын гишүүн ба нам, намын орон нутгийн байгууллага хоорондын маргааныг таслан шийдвэрлэх, намын дүрмийг хэрхэн хэрэглэх тайлбартай холбогдон гарсан маргааныг таслан шийдвэрлэх зорилгоор нам мөн намын дээд шатны орон нутгийн байгууллагын дэргэд намын хяналтын хороог байгуулж ажиллуулна. Хэд хэдэн тойргийн намын байгууллагын нэгдсэн хяналтын хороо байгуулж болно.
- (2) Намын хяналтын хорооны гишүүдийг дөрвөн жил хүртэлх хугацаагаар сонгоно. Хяналтын хорооны гишүүд нь нам эсвэл намын орон нутгийн байгууллагыг удирдах зөвлөлийн гишүүн байж үл болох ба намд болон түүний орон нутгийн байгууллагад ажил эрхлэх, эсвэл намаас тогтмол цалин орлого авдаггүй байх учиртай. Намын хяналтын хорооны гишүүд бие даан хараат бус шийдвэр гаргана.

- (3) Байнгын үндсэн дээр эсвэл онцгой тохиолдолд маргагч тал бүрээс хувь тэнцүү томилох төлөөлөгчдийг оролцуулан намын хяналтын хороог бүрдүүлэхийг намын дүрэмд тусгаж болно.
- (4) Намын хяналтын хорооны үйл ажиллагааг зохицуулсан журмыг батлан гаргана. Уг журамд талуудыг сонсох, хэргийг шударгаар хянуулах, ашиг сонирхолын зөрчлийн улмаас намын хяналтын хорооны гишүүнээс татгалзах эрхийг хангасан байна.

15-р зүйл. Намын дээд байгууллага тогтоол гаргах үйл явц

- (1) Хуульд болон намын дүрэмд өөр хувь хэмжээ тогтоогоогүй бол намын дээд байгууллага тогтоолоо ердийн олонхийн саналаар батална.
- (2) Удирдах зөвлөлийн гишүүн, төлөөлөгчдийн хурлын гишүүн болон дээд шатны намын байгууллагад суух төлөөлөгчдийг нууц санал хураалтаар сонгоно. Бусад санал хураалтыг горимын эсрэг санал гараагүй бол ил явуулж болно.
- (3) Санал, өргөдөл гаргах эрхийг хэрэгжүүлэхдээ ардчилсан зарчмыг хангах бөгөөд ялангуяа цөөнхийн саналыг хангалттай хэлэлцэх боломж олгох ёстой. Намын орон нутгийн байгууллагын хуралдаанд хамгийн багадаа доод хоёр шатны орон нутгийн байгууллагын төлөөлөгчдөд санал өргөдөл гаргах эрхийг эдлүүлнэ. Сонгууль болон санал хураалт явуулахад өөр дээд байгууллагын тогтоол шийдвэрийг удирдлага болгохыг хориглоно.

16-р зүйл. Намын орон нутгийн байгууллагад ногдуулах арга хэмжээ

- (1) Намын үндсэн зарчим, журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд л намын доод шатны орон нутгийн байгууллагыг татан буулгах, намаас хасах, тухайн намын дээд байгууллагыг огцруулах арга хэмжээ авч болно. Намын дүрэмд
 1. энэ арга хэмжээг авах шалтгаан, үндэслэлүүдийг,
 2. намын орон нутгийн дээд шатны ямар байгууллага, түүний ямар удирдах дээд байгууллага хариуцлага тооцох бүрэн эрхтэйг тус тус тусгана.
- (2) Энэ зүйлийн 1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ нам эсвэл намын орон нутгийн дээд шатны байгууллагын удирдах зөвлөл өөрийн дээд шатны намын байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагатай. Намын дараагийн их хурлаас тус арга хэмжээг баталсан шийдвэр гаргаагүй бол арга хэмжээ хүчингүй болно.
- (3) Энэ зүйлийн 1-д заасан арга хэмжээг эсэргүүцэн намын хяналтын хороонд хандаж болно.

3

СОНГУУЛЬД НЭР ДЭВШҮҮЛЭХ

БҮЛЭГ

17-р зүйл. Сонгуульд нэр дэвшүүлэх

Иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэр дэвшигчдийг нууц санал хураалтаар тодруулна. Нэр дэвшүүлэх ажиллагааг Сонгуулийн хууль болон намын дүрмээр зохицуулна.



ТӨРӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ

БҮЛЭГ

18-р зүйл. Төрөөс санхүүжүүлэх зарчмууд ба санхүүжилтийн хэмжээ

- (1) Үндсэн хуульд заасан намын ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлэхэд зориулж үйл ажиллагааных нь зардлын зохих хэсгийг төрөөс санхүүжүүлнэ. Төрөөс санхүүжилт хийхдээ Европ, Холбооны улс болон муж улсын парламентын сонгуульд үзүүлсэн амжилт, гишүүн болон сонгуульд ажилтны намдаа өгсөн татвар, хураамжийн нийт хэмжээ, хандиваар авсан хөрөнгийн хэмжээг харгалзан үзнэ.
- (2) Намд төсвөөс нэг жилд зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг 2019 онд 190 сая еврогоор урьдчилан тогтоосон болно (үнэмлэхүй дээд хязгаар). Цаашид жил бүр үнэмлэхүй дээд хязгаарыг өмнөх жилд бий болсон намын нийтлэг зардлуудын үнийн индексийн өсөлтийг харгалзан тооцох ба индексийг 0,1 хувь хүртэл бүхэлдэнэ. Үнийн индексийн суурийг гаргахад 70 хувьд нь өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг, үлдсэн 30 хувьд орон нутгийн нийтийн байгууллагад ажиллагсдын цалингийн индексийг тооцно. Өмнөх жилтэй харьцуулсан үнийн индексийн өсөлтийн тайлан мэдээг Холбооны улсын статистикийн ерөнхий хорооны дарга жил бүрийн 4-р сарын 30-наас өмнө Бундестагт ирүүлнэ. Бундестагийн ерөнхийлөгч жил бүрийн 5-р сарын 31-нээс өмнө тухайн жилд намуудад төсвөөс зарцуулах нийт хөрөнгийн үнэмлэхүй дээд хязгаарыг үнийн өсөлтийг харгалзан бүхэл еврогоор шинээр тооцон гаргаж парламентын хэвлэлийн материал хэлбэрээр нийтэлнэ.
- (3) Намд жил бүр төрийн санхүүжилтийн хүрээнд дараах мөнгийг олгоно:

1. намын нэрсийн жагсаалтаар авсан хүчинтэй санал бүрт 0,83 евро эсвэл
2. намын нэрсийн жагсаалтаар сонгуульд оролцуулаагүй намд мажоритар тойрогт нэр дэвшигч нь сонгогчдоос авсан хүчинтэй санал бүрт 0,83 евро болон
3. намын орлогын (гишүүний татвар, сонгуульт ажилтны татвар буюу хууль ёсны хандив) 1 евро бүрт төрөөс 0,45 евро. Үүнд нэг хувь хүнээс өгсөн 3 300 евро хүртэлх хандивыг л харгалзан тооцно.

4 сая хүртэлх авсан хүчинтэй саналд энэ зүйлийн 1 болон 2-р зааснаас өөр хэмжээгээр буюу нэг санал тутамд 1,0 евро намд олгоно. 2017 оноос эхлэн 1-р өгүүлбэрийн 1,2-д заасан дүн 2-р хэсгийн 2-5-р өгүүлбэрийн дагуу өснө.

- (4) Энэ зүйлийн 3-р хэсгийн 1 болон 3-т заасан төрийн санхүүжилтийг авах эрхийг зөвхөн Европын парламент эсвэл Бундестагийн сүүлийн сонгуульд намын нэрсийн жагсаалтын төлөө өгсөн нийт сонгогчдын хүчинтэй саналын 0,5 хувь болон түүнээс дээш, эсвэл муж улсын сонгуульд намын нэрсийн жагсаалтын төлөө өгсөн нийт сонгогчдын 1 болон түүнээс дээш хувийн хүчинтэй санал авсан нам эдэлнэ; энэ зүйлийн 3-р хэсгийн 1 болон 2-р өгүүлбэрт заасан төрийн санхүүжилтийг авахын тулд нам тухайн сонгуулийн үр дүнгээр заасан босгыг давсан байна. Энэ зүйлийн 3-р хэсгийн 2-т заасан төрийн санхүүжилтийг мажоритар тойрогт нэр дэвшигч нь сонгогчдын 10 болон түүнээс дээш хувийн хүчинтэй санал авсан тохиолдолд л нэр дэвшүүлсэн намд олгоно. Үндэсний цөөнхийн намд дээрх санхүүжилтийн шалгуур үйлчлэхгүй.
- (5) Намд олгох төрийн санхүүжилтийн хэмжээ нь энэ хуулийн 24-р зүйлийн 4-р хэсгийн 1-7-д заасан намын орлогын нийлбэр дүнгээс илүү байж болохгүй (харьцангуй дээд хязгаар). Бүх намд олгох төрийн санхүүжилтийн нийлбэр дүн үнэмлэхүй дээд хязгаарыг давж болохгүй.
- (6) Холбооны улсын ерөнхийлөгч намын санхүүжилтийн асуудлаар хараат бус шинжээчдээс бүрдсэн комиссийг томилж болно.
- (7) Нам тарсан, намыг хориглосон бол нам оршин тогтнохоо больсон цаг мөчөөс тухайн намд олгох төрийн санхүүжилтийг зогсооно. Мөн үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 46а зүйлийн дагуу үндсэн хуулийн цэц зохих дүгнэлт гаргасан цаг мөчөөс энэ заалт хүчин төгөлдөр болно.

19-р зүйл. Төрийн санхүүжилт авах тухай өргөдөл гаргах

- (1) Эрх үүссэн жилийн санхүүжилт авах зорилгоор төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоолгох, улмаар санхүүжилт олгохыг хүссэн өргөдлөө нам тухайн

жилийн 9-р сарын 20-оос өмнө Бундестагийн ерөнхийлөгчид гаргана. Өргөдлийг намын дүрмийн дагуу санхүү хариуцсан намын удирдах зөвлөлийн гишүүн гаргах бөгөөд өргөдөлд намын шуудангийн хаяг, намын аль нэг банк дахь дансны дугаарыг бичсэн байна. Намын төв байгууллага нь нийт намыг төлөөлж нэгдсэн өргөдөл гаргахад хангалттай. Хэсэгчилсэн санхүүжилтийн өргөдлүүдийг мөн хүлээн зөвшөөрнө. Эрх үүссэн жилийн өмнөх онд Бундестагийн ерөнхийлөгч санхүүжилтийн хэмжээг тогтоосон шийдвэр гаргасан бол эрх үүссэн жилд нам шинээр өргөдөл гаргах шаардлагагүй. Санхүүжилтийн хэмжээнд нөлөөлөх өөрчлөлтүүд гарсан бол Бундестагийн ерөнхийлөгчид даруй мэдэгдэнэ. Үүнийг цаг тухайд нь мэдэгдээгүй бол үр дагаварыг нам хариуцна.

- (2) Нам төрийн санхүүжилтээс урьдчилгаа авах хүсэлтэй бол санхүүжилт хийгдэх өмнөх сарын 15-аас өмнө өргөдлөө Бундестагийн ерөнхийлөгчид гаргана. Өргөдөлд тухайн жилдээ удаа дараа урьдчилгаа авах хүсэлт гаргаж болно. Энэ зүйлийн 1-р хэсгийн 5-7-р өгүүлбэр зохих ёсоор үйлчилнэ.

19а зүйл. Санхүүжилтийн хэмжээг тогтоох ажиллагаа

- (1) Бундестагийн ерөнхийлөгч жил бүрийн 2-р сарын 15 хүртэлх хугацаанд төрөөс санхүүжилт авах эрх бүхий нам бүрт олгох өмнөх оны (эрх үүссэн оны) санхүүжилтийн хэмжээг тогтооно. Энэ хуулийн 5-р бүлэгт заасан шаардлагуудыг хангасан намын тайланг үндэслэн, 18-р зүйл болон 19а зүйлийг баримтлан Бундестагийн ерөнхийлөгч санхүүжилтийн хэмжээг тогтоож олгоно. Санхүүжилтийн хэмжээг тогтоохоос өмнө энэ хуулийн 23а зүйлийн 2-р хэсгийн дагуу Бундестагийн ерөнхийлөгч намын тайланг нягтлан шалгах ажиллагааг үүсгэсэн бол санхүүжилтийн хэмжээг түр тогтоож, намаас эргэн төлж болзошгүй дүнтэй (энэ хуулийн 31а – 31с зүйл) дүйцэх баталгаа гаргуулан санхүүжилтийг олгоно. Нягтлан шалгах ажиллагаа дууссаны дараа санхүүжилтийн хэмжээг эцэслэн тогтооно.
- (2) Санхүүжилтийн хэмжээг тогтоох үндэс суурь нь санхүүжилт авах эрхтэй намын эрх үүссэн оны 12 дугар сарын 31-нээс өмнө хамгийн суулд явагдсан Европ, Холбооны улсын болон муж улсын сонгуулиар авсан хүчинтэй саналын тоо болон өмнөх жилийн намын тайланд тусгаж нийтэлсэн жилийн хандивын орлого (18-р зүйлийн 3-р хэсгийн 1-р өгүүлбэрийн 3) байна. Бундестагийн ерөнхийлөгч нам бүрийн сонгуулиар авсан хүчинтэй саналын тоог энэ хуулийн 18-р зүйлийн 4-г харгалзан нэгтгэн бүртгэнэ.
- (3) Нам тайлант жилийн дараах хуанлийн жилийн 9-р сарын 30-ны дотор тайлангаа Бундестагийн ерөнхийлөгчид хүргүүлнэ. Тайлан хүлээн авах хугацааг Бундестагийн ерөнхийлөгч 3 хүртэлх сараар сунгаж болно.

Хугацаандаа тайлангаа ирүүлээгүйн улмаас орлогод суурилсан төрийн санхүүжилтийн хэсгээ авах боломжоо нам бүрмөсөн алдана. Эрх үүссэн жилийн дараах хуанлийн жилийн 12-р сарын 31 хүртэл тайлангаа ирүүлээгүй бол нам сонгуульд авсан саналын тоонд суурилсан төрийн санхүүжилтийн хэсгээ авах боломжоо бүрмөсөн алдана. Тайлангийн агуулга алдаатай эсэхээс үл хамааран тайлангаа энэ хуулийн 24-р зүйлд бүтцийн заасан хэлбэртэй, 30-р зүйлийн 2-р хэсэгт заасан аудитын шалгалтын тэмдэглэлтэй заасан хугацаанд ирүүлбэл хугацаа баримталсанд тооцно. Бусад намд тогтоосон санхүүжилтийн хэмжээ, олголт нь тухайн нэг намын үйлдлээс шалтгаалан өөрчлөгдөхгүй.

- (4) Энэ хуулийн 18-р зүйлийн 5-р хэсэгт дурдсан санхүүжилтийн харьцангуй дээд хязгаарыг тооцон бодоход тайлант жилд авсан, тайланд нийтлэгдсэн намын орлогын хэмжээг (24-р зүйлийн 4-ийн № 1-7) үндэслэнэ. Үүнд аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогоос зардлуудыг (24-р зүйлийн 4-р хэсгийн 5) хаасан дүнг харгалзан үзнэ.
- (5) Төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоохдоо эхлээд нам бүрээр (18-р зүйлийн 5-р хэсэг) санхүүжилтийн харьцангуй дээд хязгаарыг, дараа нь (18-р зүйлийн 2-р хэсэг) санхүүжилтийн үнэмлэхүй дээд хязгаарыг баримтлана. Төрийн санхүүжилт үнэмлэхүй дээд хязгаараас давж хэтрэх тооцоо гарсан бол үнэмлэхүй дээд хязгаартай тэнцүү нийт санхүүжилтийг намуудад ногдох хувь хэмжээгээр нь олгоно.
- (6) Муж улсын парламентын сонгуульд оролцсон намын тус сонгуулиар авсан санал бүрийг 0,50 еврогоор тооцож, төрийн санхүүжилтийг муж улсын намын байгууллагад нь олгоно. Энэ зүйлийн 5-р хэсэгт дурдсан санхүүжилтээс хасаж болзошгүй дүнг (энэ хуулийн 21-р зүйлийн 1-ийн 1-р өгүүлбэрийн 2-р тохиолдолд) Холбооны улсын төсвөөс олгох санхүүжилтээс суутган тооцож болно. Төрийн бусад санхүүжилтийг намын төв байгууллагад, муж улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг намын тухайн муж улсын байгууллагад олгоно.

Тэмдэглэл

(+++ 19-р зүйлийн, 4-р хэсгийн 2-р өгүүлбэр: Хэрэглэхэд 39-р зүйлийн, 5-р хэсгийн 2-р өгүүлбэрийг харьцуулах +++)

20-р зүйл. Хэсэгчилсэн санхүүжилт

- (1) Эрх бүхий намд санхүүжилтийг урьдчилгаа хэлбэрээр Бундестагийн Ерөнхийлөгчийн тогтоосон хэмжээгээр хэсэгчлэн олгож болно. Тооцоо хийх

суурь нь өмнөх жилд нам бүрт төрөөс олгосон санхүүжилтийн хэмжээ байна. Хэсэгчилсэн санхүүжилтийн мөнгийг 2-р сарын 15, 5-р сарын 15, 8-р сарын 15, 11-р сарын 15-аас өмнө тус тус олгоно. Хэсэгчилсэн санхүүжилтийн хэмжээ нь тус бүр өмнөх жилийн нийт төрийн санхүүжилтийн 25 хувиас хэтэрч болохгүй. Тухайн намд олгосон санжүүжилтийг буюу хэсгийг нь тус нам буцааж улсад төлөх үүрэг үүсэх сэжүүр байвал намаас барьцаа, баталгаа шаардаж болно.

- (2) Төрөөс олгох санхүүжилтийн тогтоосон хэмжээнээс илүү авсан, эсвэл санхүүжилт авах бодит эрх үүсээгүй тохиолдолд тухайн нам авсан урьдчилгаа санхүүжилтийг даруй улсад буцааж төлнө. Урьдчилгаа санхүүжилт зохих хэмжээнээс хэтэрсэн нь тогтоогдвол Бундестагийн ерөнхийлөгч улсад буцааж төлөх хэмжээг заасан захиргааны актаар дүгнэлт гаргаж, намд олгох дараагийн санхүүжилтээс шууд хасна.
- (3) Энэ хуулийн 19а зүйлийн 6-р хэсэг зохих ёсоор үйлчилнэ.

21-р зүйл. Төсвөөс хөрөнгө гаргах ба Төрийн аудитын хороогоор шалгуулах

- (1) Энэ хуулийн 18, 20-р зүйлд заасан хөрөнгийг энэ хуулийн 19а зүйлийн 6-р хэсгийн 1-р өгүүлбэрт дурдсан тохиолдолд муж улсын төсвөөс, бусад санхүүжилтийг улсын төвлөрсөн төсвөөс Бундестагийн ерөнхийлөгчийн шийдвэрээр намд олгоно. Бундестагийн ерөнхийлөгч муж улсуудын намын байгууллагад хуваарилсан хөрөнгийг муж улсад албан ёсоор мэдэгдэнэ.
- (2) Төрийн аудитын хороо нь Бундестагийн ерөнхийлөгч энэ хуулийн энэ бүлгийн дагуу намд олгох төсвийн хөрөнгийг зөв тогтоож олгосон ба энэ хуулийн 23а зүйлд заасан ажиллагаа журам ёсоор явагдсан эсэхийг нягтлан шалгана.

22-р зүйл. Намын дотоод санхүүгийн зохицуулалт

Намын төв байгууллага нь харьяа муж улсын намын байгууллага хоорондын санхүүгийн тэгш тэнцвэртэй байдлыг хангахад анхаарна.

5

ТАЙЛАГНАХ

БҮЛЭГ

23-р зүйл. Нийтэд тайлагнах үүрэг

- (1) Намын удирдах зөвлөл намын нийт өмч хөрөнгө, түүний эх үүсвэр, зарцуулалтын талаар хуанлийн жилийн эцэст үнэнч шударгаар олон нийтэд ил тодоор тайлагнах үүрэгтэй. Тайланг Бундестагийн ерөнхийлөгчид хүргүүлэхээс өмнө намын удирдах зөвлөлөөр хэлэлцэнэ. Холбооны улс, муж улсын намын байгууллага болон түүнтэй дүйцэх намын орон нутгийн нэгжийн удирдах зөвлөл тус тус өөрийн тайланг гаргах асуудлыг хариуцна. Тайланг баталгаажуулж намын дарга болон санхүүгийн асуудал хариуцсан удирдах зөвлөлийн гишүүн гарын үсэг зурна. Санхүүгийн асуудал хариуцсан удирдах зөвлөлийн гишүүнийг намын их хурлаас сонгох, эсвэл намын дүрэмд заасан санхүү хариуцсан дээд байгууллагаас томилно. Санхүүгийн асуудал хариуцсан удирдах зөвлөлийн гишүүний зурсан гарын үсэг нь тайланд агуулагдаж буй мэдээлэл үнэн зөв хийгдсэний баталгаа болно. Намын нэгдсэн тайланг намын их хурлаас сонгогдсон санхүүгийн асуудал хариуцсан Холбооны улсын намын удирдах зөвлөлийн гишүүн эсвэл намын дүрэмд заасны дагуу санхүү хариуцсан дээд байгууллагаас томилогдсон удирдах зөвлөлийн гишүүн эмхэтгэж гарын үсэг зурна.
- (2) Намын тайланг аудитор эсвэл аудитын компаниар энэ хуулийн 29 – 31-р зүйлд заасны дагуу хянуулна. Энэ хуулийн 18-р зүйлийн 4-р хэсгийн 1-р өгүүлбэрийн шаардлагыг хангаагүй нам тайлангаа тангараг өргөсөн нягтлан бодогчоор эсвэл нягтлан бодох компаниар хянуулж болно. Тайланг энэ хуулийн 19а зүйлийн 3-р хэсгийн 1-р өгүүлбэрт заасан хугацаанд Бундестагийн ерөнхийлөгчид хүргүүлнэ. Бундестагийн ерөнхийлөгч тайланг

парламентын хэвлэлийн материал хэлбэрээр нийтэлнэ. Энэ хуулийн 18-р зүйлийн 4-р хэсгийн 1-р өгүүлбэрийн шаардлагыг хангаж чадахгүй нам тухайн тайлант жилд 5 000 еврогоос бага өмч хөрөнгө болон орлоготой байсан бол тайлангаа хянуулахгүйгээр Бундестагийн ерөнхийлөгчид хүргүүлж болно. Бундестагийн ерөнхийлөгч хянуулаагүй өөрт нь ирүүлсэн тайланг нийтэлж болно. Тайлан нийтлэгдсэнээс хойш болох дараагийн намын их хурлаар тайланг хэлэлцүүлнэ.

- (3) Энэ хуулийн 5-р бүлгийн заалтуудын шаардлагыг тайлан хангасан эсэхийг Бундестагийн ерөнхийлөгч 23а зүйлийн дагуу нягтлан шалгана. Энэхүү шалгалтын дүнг энэ зүйлийн 4-р хэсэгт заасан мэдээлэлд тусгана.
- (4) Бундестагийн ерөнхийлөгч хоёр жил тутам намуудын санхүүгийн байдал болон намуудын тайлангийн талаар Бундестагт мэдээлэл хийнэ. Үүний зэрэгцээ жил бүр намуудын орлого, зарлага, хөрөнгийн байдлын талаар харьцуулсан товч мэдээлэл бэлтгэж гаргана. Эдгээр мэдээлэл парламентын хэвлэлийн материал хэлбэртэй Бундестагт тараагдана.

23а зүйл. Тайланг нягтлан шалгах

- (1) Өөрт нь ирүүлсэн намын тайланг Бундестагийн ерөнхийлөгч хэлбэр болон агуулгын хувьд зөв байгаа эсэхийг нягтлан шалгана. Тайлан энэ хуулийн 5-р бүлгийн заалтуудад нийцэж байгаа эсэхийг тэрбээр тогтооно. Зөвхөн энэ хуулийн 24-р зүйлийн 2-р хэсэгт заасан хугацаа дуусахаас л өмнө нягтлан шалгах ажиллагааг дахин явуулж болно.
- (2) Хэрэв намын тайланд байгаа мэдээлэл үнэн эсэхэд эргэлзэх тодорхой үндэслэл шалтгаан Бундестагийн ерөнхийлөгчид байвал тэрбээр тухайн намд тайлбар хийх боломжийг олгоно. Бундестагийн ерөнхийлөгч тайлан үнэн зөв гэх баталгааг аудитор, аудитын компани, тангараг өргөсөн нягтлан бодогч, нягтлан бодох компаниар гаргуулахыг намаас шаардах эрхтэй.
- (3) Энэ зүйлийн 2-р хэсгийн дагуу намаас гаргасан тайлбар нь тайлан үнэн зөв эсэхэд эргэлзэх тодорхой үндэслэл шалтгааныг арилгаж чадаагүй бол Бундестагийн ерөнхийлөгч намтай зөвшилцөж өөр аудитор буюу аудитын компанийг татан оролцуулж намын тайлан энэ хуулийн 5-р бүлгийн заалтуудад нийцэх эсэхийг шалгуулна. Бундестагийн ерөнхийлөгчөөс даалгавар авсан аудитор холбогдох баримт материалтай танилцах боломжийг нам бүрдүүлэх үүрэгтэй. Дахин нягтлах ажиллагааны зардлыг Бундестагийн ерөнхийлөгч хариуцна.
- (4) Нягтлан шалгах ажиллагаа дуусгавар болсоны дараа Бундестагийн ерөнхийлөгч шийдвэр гаргана. Шийдвэр нь тайланд алдаа зөрчил байсан эсэхийг тогтоож, тайланг зөрчил алдаатай гаргасан бол үүний улмаас намд

олгосон санхүүжилтийн зөрүүг мөн тогтооно. Түүнчлэн шийдвэртээ орлого, зарлагын тайлангийн баланс хууль тогтоомжийг зөрчсөн, эсвэл эд хөрөнгийн балансыг буруу гаргасан, эсвэл тайлбар хэсэгт (24-р зүйлийн 7) буруу тайлбар хийсэн алдаа зөрчлийг заана.

- (5) Алдаа зөрчилтэй тайлан ирүүлсэн нам тайлангийн алдаа зөрчлийг арилгаж Бундестагийн ерөнхийлөгчийн шийдвэрийн дагуу тайлангаа бүрэн эсвэл хэсэгчлэн шинэчилэн ирүүлнэ. Шинэчилсэн тайлангийн үнэн зөвийг аудитор, аудитын компани, тангараг өргөсөн нягтлан бодогч, нягтлан бодох компаниар баталгаажуулна. Тухайн тогтоогдсон алдаа зөрчил 10 000 евро хүрэхгүй, эсвэл нийт тайлант жилийн алдаа зөрчил нам тус бүрт 50 000 еврогоос бага байвал энэ зүйлийн 5-р хэсгийн 1, 2-р өгүүлбэрийн дагуу тайланг шинэчлэхгүйгээр дараа жилийн тайланд залруулан тусгаж болно.
- (6) Алдаа зөрчлийг арилган шинэчилсэн тайланг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн парламентын хэвлэлийн материал хэлбэрээр нийтэлнэ.
- (7) Тайланг нягтлан шалгах ажиллагааны явцад олж авсан боловч намын тайланд шууд хамаарахгүй мэдээллийг нийтэлж болохгүй бөгөөд Холбооны Герман улсын төрийн бусад байгууллагад дамжуулахгүй. Хяналт шалгалт дууссаны дараа эдгээр мэдээллийг Бундестагийн ерөнхийлөгч даруй устгах үүрэгтэй.

236 зүйл. Тайлангийн алдаа, зөрчлийг мэдүүлэх үүрэг

- (1) Нам өөрөө тайланд нь алдаа, зөрчил байгааг Бундестагийн ерөнхийлөгчид тайланг албан ёсоор хугацаандаа хүргүүлсний дараа мэдвэл алдаа, зөрчил илэрсэнийг даруй Бундестагийн ерөнхийлөгчид бичгээр мэдүүлэх үүрэгтэй.
- (2) Алдаа зөрчлийн тухай Бундестагийн ерөнхийлөгчид мэдүүлсэн цаг мөчид тайланд алдаа, зөрчил агуулагдсан тухай олон нийт болон Бундестагийн ерөнхийлөгч ямар нэгэн мэдээлэлгүй байсан, эсвэл албан ёсны хяналт шалгалтын үйл ажиллагааны явцад алдаа зөрчлийг илрүүлээгүй бөгөөд нам алдаа зөрчлийг бүрэн хэмжээгээр ил тод болгож залруулсан бол энэ хуулийн 31б эсвэл 31в зүйлд заасан эрх зүйн үр дагавар үүсэхгүй. Хууль бусаар олж авсан санхүүгийн хэрэгслийг Бундестагийн ерөнхийлөгчид түүний тогтоосон хугацаанд нам шилжүүлэн өгнө.
- (3) 23а зүйлийн 5 болон 6-р хэсэг зохих ёсоор үйлчилнэ.

24-р зүйл. Тайлан

- (1) Тайлан нь энэ хуулийн заалтуудын дагуу гүйцэтгэсэн орлого, зарлагын тооцоо, түүнтэй холбоотой өмч хөрөнгийн баланс болон тайлбар хэсгээс бүрдэнэ. Нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг баримтлан бодит нөхцөл

байдалд нийцүүлэн намын хөрөнгийн эх үүсвэр, зарцуулалт болон намын өмч хөрөнгийн мэдээллийг тайланд тусгана.

- (2) Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нам тайлан гаргахдаа бүх аж ахуй эрхлэгчдэд хүчин төгөлдөр үйлчлэх тайлан тооцоо гаргах тухай хууль тогтоомжийг ялангуяа эд хөрөнгө бүртгэх, үнэлэх ажиллагаандаа хэрэглэнэ. Бүртгэлийн анхан шатны баримт материал, данс хөтлөлт, баланс, тайлангуудыг 10 жил хадгална. Энэ хугацааг тайлант жил дууссанаас хойш тооцно.
- (3) Намын нэгдсэн тайланд намын төв байгууллагын тайлан, муж улсын намын байгууллагуудын тайланг доод шатны намын орон нутгийн нэгжүүдийн тайлангийн хамт тус тус хавсаргана. Муж улсын намын байгууллага болон доод шатны намын орон нутгийн нэгжийн тайланд хандив өргөсөн бүх хандивлагчийн овог нэр, хаягийг тус бүр өргөсөн хандивын хэмжээтэй хамт бичиж тусгана. Намын төв байгууллага энэ хандив болон хандивлагчдын жагсаалтыг нэгтгэж, авсан нийт хандивын хэмжээ, тодорхой нэг хандивлагчаас өргөсөн хандивын нийлбэр дүнг нэгтгэн гаргана. Муж улсын намын байгууллага нь намын доод шатны орон нутгийн нэгжүүдээс ирүүлсэн тайлангуудыг өөрийн тайлангийн материалуудын хамт хадгална.
- (4) Орлогод дараах зүйлийг бүртгэнэ:
 1. намын гишүүдийн татвар,
 2. сонгуульт ажилтны татвар буюу ижил төстэй тогтмол хураамж,
 3. хувь хүний өргөсөн хандив,
 4. хуулийн этгээдийн өргөсөн хандив,
 5. аж ахуйн үйл ажиллагааны,
 - 5а. хувь оролцооны орлого,
 6. бусад өмч хөрөнгийн орлого,
 7. арга хэмжээ зохион байгуулах, ном болон нийтлэл хэвлэн борлуулах, бусад үйл ажиллагаанаас олсон орлого,
 8. төрөөс олгосон хөрөнгө мөнгө,
 9. бусад орлого,
 10. намын салбар байгууллагаас өгсөн татаас болон
 11. 1-10 дугаарын нийт орлого
- (5) Зардалд дараах зүйлийг бүртгэнэ:
 1. боловсон хүчний цалин хөлс,
 2. эд материалын зардал,
 - а) өдөр тутмын ажиллагааны зардал,
 - б) улс төрийн ажлын зардал,
 - в) сонгуулийн зардал,
 - г) эд хөрөнгийн ашиглалтын зардал ба үүнтэй холбоотой хүү төлөлт,
 - д) бусад хүү төлөлт,
 - е) аж ахуй эрхлэх зардал,

- ё) бусад зардал,
- 3. Салбар байгууллагад олгосон татаас болон
- 4. 1-3 дугаарын нийт зардал

(6) Өмч хөрөнгийн балансад дараах зүйлийг бүртгэнэ:

1. Эзэмшлийн эд хөрөнгө:

А. Хувьцаа болон хувь эзэмшил:

I. эд хөрөнгө:

- 1. байшин, газар,
- 2. ажлын байрны тоноглол,

II. санхүүгийн хөрөнгө:

- 1. аж ахуйн нэгжид оруулсан хувь,
- 2. бусад санхүүгийн хөрөнгө оруулалт;

Б. Эргэлтийн хөрөнгө:

- I. намын салбар байгууллагаас авах авлага,
- II. төрөөс авах санхүүжилт,
- III. бэлэн мөнгөний үлдэгдэл,
- IV. бусад эд хөрөнгө;

А. Нийт эзэмшлийн эд хөрөнгө (А,Б-ийн нийлбэр);

1. Өглөг:

А. Хуримтлал:

- I. тэтгэврийн санд төлөх мөнгө,
- II. бусад хуримтлал;

Б. Өр зээл:

- I. намын салбар байгууллагад өгөх мөнгө,
- II. төрийн санхүүжилтийн төрд буцааж төлөх мөнгө,
- III. санхүүгийн байгууллагаас авсан зээл,
- IV. бусад зээлдүүлэгчдээс авсан зээл,
- V. бусад өглөг;

А. Нийт өглөг (А,Б-ийн нийлбэр);

2. Цэвэр хөрөнгө (нэмэх эсвэл хасах).

(7) Өмч хөрөнгийн балансад тайлбар хэсгийг хавсаргах бөгөөд тайлбар хэсэгт заавал дараах зүйлийг нэн тэргүүнд тусгана:

- 1. Энэ зүйлийн 6-р хэсгийн 1-ийн А II1-д заасан намын хувь оролцооны жагсаалт болон эдгээражахуйн нэгжийн жилийн нэцсийн тайланд тусгасан бусдын шууд буюу шууд бус эзэмшлийн хувь, хувьцааны жагсаалт, хувь нийлүүлсэн болон хувьцаат компаниудын нэр, хаяг, намын оролцооны

хувь хэмжээ, нэрлэсэн үнэ, аж ахуйн нэгжийн дүрмийн сан, сүүлийн жилийн ашиг алдагдлын үр дүнг бичнэ. Аж ахуйн нэгжүүдийн жилийн тайланд хувь эзэмшигчдийн тухай тусгасан мэдээллийг намын тайланд шилжүүлэн тусгана. Хувь оролцоо гэдэгт Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуулийн 271-р зүйлийн 1-р хэсэгт тодорхойлсон эзэмшил хувийг ойлгоно;

2. Хэвлэл мэдээллийн компанид хувь эзэмшигч бол тус компанийн гол бүтээгдэхүүнийг нэрлэнэ;
3. Таван жил тутам үл хөдлөх хөрөнгө болон аж ахуйн нэгжид эзэмших хувьд Үнэлгээний тухай хуулийн дагуу хийлгэсэн үнэлгээ (Үнэлгээ хийх тухай хуулийн 145-р зүйлийн дагуу үл хөдлөх хөрөнгө, газрыг үнэлэх).

(8) Хувь хүн өгсөн 3 300 хүртэлх еврогийн хандивуудын нийт дүн болон 3 300 еврогоос илүү мөнгө хандивласан хувь хүмүүсийн хандивын нийт дүнг тусгайлан тэмдэглэнэ.

(9) Тайлангийн оршил хэсэгт дараах товч мэдээллийг нэгтгэн тавьсан байна:

1. энэ зүйлийн 4-р зүйлийн 1-9 хэсгийн дагуу нийт намын орлого болон түүний нийлбэр,
2. энэ зүйлийн 5-р зүйлийн 1-2 хэсгийн дагуу нийт намын зардал болон түүний нийлбэр,
3. ашиг эсвэл алдагдлын дүн мэдээ,
4. энэ зүйлийн 6-р зүйлийн 1-р хэсгийн дагуу нийт намын эзэмшлийн эд хөрөнгө болон нийлбэр дүн,
5. энэ зүйлийн 6-р зүйлийн 2-р хэсгийн дагуу нийт намын өглөг болон нийлбэр дүн,
6. цэвэр хөрөнгө (нэмэх эсвэл хасах),
7. намын төв байгууллага, муж улс болон түүний харьяа орон нутгийн намын байгууллага зэрэг зохион байгуулалтын гурван түвшний нийт орлого зарлага, ашиг алдагдал, цэвэр хөрөнгө.

Энэ хэсгийн 1,2-д орлого, зарлага түс бүрийн хэмжээг үнэмлэхүй мөнгөн дүнгээр илэрхийлэхийн зэрэгцээ нийт орлого, зарлагад эзлэх хувийг нь мөн тооцож бичнэ. Түүнчлэн өнгөрсөн оны дүнтэй харьцуулалт хийсэн байна.

(10) Намын гишүүдийн тоог тайлант жилийн 12-р сарын 31-ны байдлаар заана.

(11) Нам тайландаа нэмэлт тайлбар хавсаргаж болно.

(12) Залуучуудын улс төрийн байгууллагад төрөөс тусгай зориулалтаар олгосон санхүүжилтийг намын санхүүжилтийн үнэмлэхүй дээд хязгаарыг тогтооход тооцохгүй. Энэ санхүүжилт намын тайлангийн орлого зарлагын тооцоонд хамаарахгүй боловч тайланд бүртгэсэн байна.

25-р зүйл. Хандив

- (1) Нам хандив хүлээн авах эрхтэй. 1 000 хүртэлх еврогийн хандивыг бэлнээр авч болно. Хандивыг хүлээж авсан намын гишүүн намын дүрмээр санхүүгийн асуудал хариуцсан намын удирдах зөвлөлийн гишүүнд хандивыг даруй дамжуулах үүрэгтэй. Санхүүгийн асуудал хариуцсан намын удирдах зөвлөлийн гишүүн эсвэл санхүүгийн асуудал хариуцсан ажилтны мэдэлд хандивын мөнгө очсон цаг мөчөөс нам хандив авсан гэж тооцно. Хандив орж ирэнгүүт хүлээн авахаас татгалзаж мөнгийг хандивлагчид нэн даруй буцаавал намыг хандив авсанд тооцохгүй.
- (2) Дараах тохиолдолд нам хандив авч болохгүй:
1. төрийн болон нийтийн байгууллагаас, Холбооны болон муж улсын парламент, орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал дахь намын бүлэг, зөвлөлөөс өргөх хандив;
 2. улс төрийн сан, байгууллага болон өөрийн дүрэм, сангийн чиг үүрэг буюу бусад дүрэм журмын дагуу бодит үйл ажиллагаа нь зөвхөн нийтэд үйлчлэх, буяны болон шашны чиглэлтэй хувь хүмүүсийн холбоо, хөрөнгө удирдах нэгдлээс өргөх хандив;
 3. энэ хууль үйлчлэх нутаг дэвсгэрийн гаднаас зөвхөн:
 - а) үндсэн хуулийн дагуу Герман улсын иргэн болох хувь хүн, Европын холбооны гишүүн улсын иргэн, түүнчлэн Герман улс эсвэл Европын холбооны улсын иргэний 50 –аас дээш хувийн эзэмшилд буй аж ахуйн нэгжээс өргөх хандив, эсвэл Европын холбооны улсад төвтэй аж ахуйн нэгжээс шууд намд өргөх хандивыг тус тус зөвшөөрнө,
 - б) уламжлалт үндэсний цөөнхийн нам тухайн цөөнхтэй угсаа гарал нэгтэй үндэстэн оршин суух, Холбооны Герман улстай хөрш улсаас хандив авч болно,
 - в) гадаадын иргэнээс өргөсөн 1 000 еврогоос бага хандивыг зөвшөөрнө;
 4. Мэргэжлийн холбооноос цааш нь улс төрийн намд дамжуулах нөхцөлтэй өргөх хандив;
 5. Төрийн болон нийтийн өмчийн оролцоо нь 25 хувиас илүү төрийн болон нийтийн өмчит, төрөөс удирдаж буй аж ахуйн нэгжээс өргөх хандив;
 6. Хандивлагчийн нэрийг тодорхойлох боломжгүй буюу өөрийгөө нууцлахыг хүссэн тохиолдолд 500 еврогоос илүү хандивыг, эсвэл нэр нь тодорхойгүй гуравдагч этгээдийн хандивыг дамжуулж буй нь илэрхий бол;
 7. Хандивыг тус намаас хандивлагчид эдийн засаг, улс төрийн давуу байдал олгох хүлээлттэй өгсөн, эсвэл шан харамж болох нь илт байвал;
 8. Хандив болон хандивлагч зуучлах төлбөрт үйлчилгээ үзүүлэгч гуравдагч этгээдэд намаас олгох хөлс нь оруулах хандивын 25 хувиас давсан тохиолдолд.

- (3) Нам буюу түүний нэг эсвэл хэд хэдэн орон нутгийн байгууллагад нэг гишүүн, намын сонгуульт албан тушаалтан гишүүн, хандивлагч жилд 10 000 еврогоос илүү нийт дүнтэй татвар буюу хандив өгсөн бол тухайн албан тушаалтан буюу хандивлагчийн нэр хаяг, татвар болон хандивын хэмжээг тайланд тусгайлан тэмдэглэнэ. Нэг хандивлагчаас өргөсөн нэг удаагийн хандив 50 000 еврогоос илүү байх тохиолдолд нам энэ хандивыг Бундестагийн ерөнхийлөгчид даруй мэдүүлэх үүрэгтэй. Бундестагийн ерөнхийлөгч парламентын хэвлэлийн материал хэлбэрээр энэ хандивыг хандивлагчийн нэрийн хамт цаг алдалгүй нийтэлнэ.
- (4) Энэ зүйлийн 2-р хэсэгт заасны дагууул зөвшөөрөх хандивыг нам Бундестагийн ерөнхийлөгчид даруй буюу цаад хугацаа нь тухайн жилийн тайлан (19а зүйлийн 3-р хэсэг) ирүүлэхдээ шилжүүлсэн байна.

Тэмдэглэл

(+++ 25-р зүйл, 3-р хэсгийн 1-р өгүүлбэр: Хэрэглэхэд 39-р зүйл, 5-р хэсгийн 3-р өгүүлбэрийг харьцуулах +++)

26-р зүйл. Орлогын тухай ойлголт

- (1) Энэ хуулийн 24-р зүйлийн 4-р хэсэгт орлогын төрлүүдийн онцгойлон заагаагүй бол намын орлого гэдэгт намын хүлээн авсан мөнгө буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх бараа үйлчилгээг ойлгоно. Орлогод мөн нийтлэг үүсэх төлбөрөөс чөлөөлөх, намыг сурталчилсан ажил, арга хэмжээний зардлыг бусдаар даалгах, хуримтлалыг цуцлах, эзэмшлийн хувь, эд хөрөнгийн хувьцааны үнэлгээний өсөлтийг тооцно.
- (2) Бүх орлогыг тайланд зохих ёсоор бүрэн дүнгээр бүртгэн, өмч хөрөнгийн балансд тусгана.
- (3) Мөнгөн бус хөрөнгийг ижил төстэй хөрөнгийн зах зээлийн жишиг үнээр үнэлж мөнгөн дүнгээр бүртгэнэ.
- (4) Намд дэмжлэг үзүүлдэг орон тооны бус ажилтан зарчмын хувьд цалингүй ажиллана. Аж ахуйн үйл ажиллагааны бус журмаар үнэ төлбөргүй намд хүлээлгэн өгсөн эд зүйл, үзүүлсэн үйлчилгээг орлогод тооцохгүй. Гаргасан зардлыг нөхөн төлөх асуудлыг энэ заалт хөндөхгүй.
- (5) Намын гишүүдийн татвар болон төрийн санхүүжилтийг тогтоосон квотоор намын орон нутгийн нэгжүүдэд дамжуулан хуваарилах тохиолдолд тухайн ногдол хувийг эцэслэн хүлээн авсан намын орон нутгийн байгууллага орлогодоо авч тайландаа тусгана.

26а зүйл. Зарлагын тухай ойлголт

- (1) Энэ хуулийн 24-р зүйлийн 5-р хэсэгт зарлагын төрлүүдийг онцгойлон заагаагүй бол зарлага гэдэгт намын зарцуулж хэрэглэсэн мөнгө буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх бараа үйлчилгээг ойлгох бөгөөд энэ хуулийн 26-р зүйлийн 1-р хэсгийн 2-р өгүүлбэрт дурдсан намын орлогыг зарцуулж хэрэглэхийг мөн зарлагад тооцно. Мөн эд хөрөнгийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус элэгдэл хорогдол болон хуримтлал үүсгэх хөрөнгийг зарлагад тооцно.
- (2) Энэ хуулийн 26-р зүйлийн 2-р хэсэг зохих ёсоор үйлчилнэ.
- (3) Эд зүйлийг худалдах, зарцуулахад түүний эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнээр зарлага гаргана.
- (4) Намын орон нутгийн салбар хооронд хийгдсэн дотоодын суутган тооцоонд хөрөнгө зарцуулсан салбар дээр зарлагын бүртгэл хийгдэнэ.

27-р зүйл. Орлогын тодорхой төрлүүд

- (1) Намын гишүүний татвар гэдэгт намын дүрмийн дагуу намын гишүүн намдаа тогтмол төлдөг мөнгийг ойлгоно. Намын сонгуульт албан тушаалтны татвар гэдэгт нийтийн албан тушаалд намаас сонгогдон ажиллаж буй албан тушаалтны намд гишүүний татварын зэрэгцээ тогтмол төлдөг татварыг ойлгоно. Дурдсан татвараас гадна намд өгөх бусад бүх мөнгийг хандив гэж үзнэ. Бүх төрлийн гэнэтийн зардлуудыг гишүүдэд ногдуулан хуваарилах, мөнгө цуглуулах, мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эд хөрөнгө намд өгөхийг хандивт тооцно. Энэ заалт нь нийтлэг, аж ахуйн бус журмаар намд үнэ төлбөргүй эд зүйлс шилжүүлэх, гүйцэтгэсэн гэрээт ажил, үйлчилгээний үнэ хөлсийг авахаас татгалзах, эсвэл намд буцаан шилжүүлэхэд хамаарахгүй.
- (2) Энэ хуулийн 24-р зүйлийн 4-р хэсгийн 9-д дурдсан бусад гэх орлого нь 24-р зүйлийн 3-д дурдсан аль нэг төрөлд 24-р зүйлийн 4-р хэсгийн 1-6-д дурдсан орлогын нийт дүнгийн 2 хувиас илүү байвал бусад гэх орлогыг тайланд задлан нэг бүрчлэн тайлбарлана. Үүний зэрэгцээ нэг удаагийн орлого нь 10 000 еврогоос илүү байвал энэ орлогыг нийтэд ил тод болгоно. Гэрээслэлийн дагуу намд 10 000 еврогоос илүү үнэ бүхий өмч хөрөнгө өвлүүлсэн бол нам хөрөнгийн үнийн дүн, өвлүүлэгчийн нэр, сүүлд оршин суусан хаягийг тайланд тусгана.

28-р зүйл. Өмч хөрөнгийн баланс

- (1) Худалдан авах тус бүрийн үнэ нь худалдааны татвар ороод 5 000 еврогоос дээш үнэтэй эд зүйлийг өмч хөрөнгийн балансад тусгана.

- (2) Худалдан авах болон үйлдвэрлэх өртгөөс төлөвлөгөөт элэгдэл хорогдлыг хассан үнээр хөрөнгийг бүртгэнэ. Байшин, газрын хувьд элэгдэл, хорогдол тооцохгүй.
- (3) Муж улсын намын байгууллагаас доош шатны намын орон нутгийн нэгжүүд хэдийгээр өр авлагын эрх өмнөх жилд үүссэн ч өмч хөрөнгийн балансдаа орлого зарлагын гүйлгээг бодитоор хийсэн жилд тусгаж болно. Энэ түвшний намын нэгжүүд тайлан гаргахдаа Аж ахуй үйл ажиллагааны тухай хуулийн 249-251-р зүйлийн шаардлагыг хангах үүрэг хүлээхгүй.

29-р зүйл. Тайланг хянан шалгах

- (1) Энэ хуулийн 23-р зүйлийн 2-р хэсгийн 1-д дурдсан аудитын шалгалтыг намын төв байгууллага, бүх муж улсын намын байгууллага болон аудиторын үзэмжээр сонгосон доод шатны орон нутгийн 10 нэгжийг оролцуулан явуулна. Шалгалтанд мөн нягтлан бодох бүртгэлийг хамруулна. Хяналт шалгалт хууль тогтоомжийг баримтлан сахисан эсэхийг тогтооход чиглэгдэнэ. Хяналт шалгалтыг хариуцлагатай мэргэжлийн өндөр түвшинд явуулж, алдаа болон хуулийн заалтуудын зөрчлийг олж тогтооно.
- (2) Аудитор хянан шалгах үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай тодруулга, баримт бичгийг намын удирдах зөвлөл болон түүний бүрэн эрх бүхий ажилтнаас шаардах эрхтэй. Үүнтэй холбоотойгоор аудитор тайланг гаргахад хэрэглэсэн баримт бичиг, нягтлан бодох бүртгэл, касс болон эд хөрөнгийг шалгах эрхтэй.
- (3) Шалгуулж буй намын орон нутгийн байгууллагын удирдах зөвлөлөөс тайланд тусгагдах ёстой бүх орлого, зарлага, эд хөрөнгийг бүртгэсэн тухай баталгааг аудитор бичгээр гаргаж өгнө. Баталгааг орон нутгийн доод шатны намын удирдах зөвлөлөөс гаргуулж болох ба санхүүгийн асуудал хариуцсан удирдах зөвлөлийн гишүүн бичгээр баталгаа гаргахад хангалттай.

30-р зүйл. Шалгалтын тайлан, тэмдэглэл

- (1) Шалгалтын үр дүнг бичгээр тайлагнаж, нам болон шалгуулсан орон нутгийн байгууллагын удирдах зөвлөлд хүлээлгэн өгнө.
- (2) Намын тайланг шалгаж дууссаны дараа алдаа зөрчил илрээгүй тохиолдолд аудитор өөрийн үүргээ хариуцлагатай биелүүлж, намын нягтлан бодох бүртгэл, бусад баримт бичиг болон намын удирдах зөвлөлөөс өгсөн тайлбар, тодруулгыг үндэслэн намын тайлан нь шалгалт явуулсан хүрээнд (29-р зүйлийн 1) энэ хуулийн шаардлагуудыг хангасаныг баталгаажуулж тэмдэглэл үйлдэнэ. Тайланд алдаа, зөрчил илрүүлсэн тохиолдолд аудитор дээрх шалгалтын тэмдэглэлд тайланг баталгаажуулахаас татгалзах эсвэл хэсэгчлэн

баталгаажуулна. Шалгуулсан намын орон нутгийн байгууллагыг тэмдэглэлд заана.

- (3) Шалгалтын тэмдэглэлийг намын тайланд хавсаргах бөгөөд энэ хуулийн 23-р зүйлийн 2-р хэсгийн 3-р өгүүлбэрт заасны дагуу бүрэн хэмжээгээр нийтэлнэ.

31-р зүйл. Аудитор

- (1) Дараах тохиолдолд аудитор эсвэл тангараг өргөсөн хянан шалгагч тайлангийн хянан шалгагчаар ажиллаж болохгүй:
1. Намд болон намын төлөө ажил, албан тушаал хашиж буй эсвэл сүүлийн гурван жилийн хугацаанд хашиж байсан;
 2. Хянан шалгалтын ажлын зэрэгцээ намын нягтлан бодох бүртгэлийг хөтлөхөд, эсвэл намын тайлан гаргалтанд оролцсон;
 3. Намын тайлангийн хянан шалгагчаар аж ахуйн нэгжийг ажиллуулах тохиолдолд тухайн аж ахуйн нэгжийн хууль ёсны төлөөлөгч, ажилтан, ТУЗ-ын гишүүн, хувь эзэмшигч, эзэн энэ зүйлийн 2-т заасан үндэслэлээр хянан шалгагч байх боломжгүй;
 4. Энэ зүйлийн 1-р хэсгийн 1-3-д заасан үндэслэлээр хянан шалгагч байх боломжгүй хүнийг шалгалтанд оролцуулсан.
- (2) Дараах тохиолдолд аудитын эсвэл санхүүгийн хяналтын компани намын тайлангийн хянан шалгагчаар ажиллаж болохгүй:
1. Энэ зүйлийн 1-р хэсгийн 3-д дурдсан аж ахуйн нэгжийн хувь нийлүүлэгч, эсвэл энэ зүйлийн 1-р хэсгийн 2 болон 4-д зааснаар хянан шалгагч байх боломжгүй;
 2. Түүний хууль ёсны төлөөлөгч, хувь нийлүүлэгч энэ зүйлийн 1-р хэсгийн 2-т эсвэл 3-т заасан үндэслэлээр хянан шалгагч байх боломжгүй.
- (3) Хянан шалгагч, түүний туслах ажилтан, шалгалт хийж буй аудитын болон санхүүгийн хяналтын компанийн хууль ёсны төлөөлөгч нь ажил үүргээ шударга, үнэнчээр, төвийг сахиж биелүүлэх бөгөөд нууцыг хадгалах үүрэгтэй. Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуулийн 323-р зүйл зохих ёсоор үйлчилнэ.

6

ТАЙЛАНГ БУРУУ ГАРГАСАН ТОХИОЛДОЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ХАРИУЦЛАГЫН ЗААЛТУУД

БҮЛЭГ

31а зүйл. Төрөөс олгосон санхүүжилтийг буцааж төлөх

- (1) Энэ хуулийн 18-р зүйлийн 3-р хэсгийн 1-р өгүүлбэрийн 3-т авсан татвар болон хандивын хэмжээг буруу мэдүүлсний улмаас төрөөс олгох санхүүжилтийг буруу тогтоосон бол энэ хуулийн 19а зүйлийн 1-р хэсгийн дагуу тогтоосон төрийн санхүүжилтийг Герман улсын Бундестагийн ерөнхийлөгч хүчингүй болгоно. Энэ хуулийн 23а зүйлийн 5-р хэсгийн 3-р өгүүлбэрийн дагуу алдаа зөрчлийг ирэх жилийн тайланд арилгахаар тохирсон бол энэ заалт үйлчлэхгүй. Захиргааны ажиллагааны тухай хуулийн 48-р зүйлийн 2-р хэсгийг энэ тохиолдолд хэрэглэхгүй.
- (2) Энэ хуулийн 24-р зүйлийн 2-р хэсэгт заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд тогтоосон төрийн санхүүжилтийг хүчингүй болгохгүй.
- (3) Бундестагийн ерөнхийлөгч захиргааны акт гаргаж, намаас төрд буцааж төлөх мөнгөний хэмжээг тогтооно. Энэ хугацаанд төрөөс дараагийн санхүүжилт авах эрх намд үүссэн бол Бундестагийн ерөнхийлөгч намаас буцааж төлөх мөнгийг дараагийн санхүүжилтээс суутгаж тооцно.
- (4) Бусад нам санхүүжилтийн хэмжээг тогтоох болон олгоход тухайн намын дээрх асуудал нөлөөлөхгүй.
- (5) Энэ зүйлийн 1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, дутагдалыг муж улсын намын байгууллага, доод шатны намын орон нутгийн нэгж гаргах тохиолдолд зохицуулах заалтыг нам дүрмэндээ тусгана.

316 зүйл. Тайлангийн алдаа

Бундестагийн ерөнхийлөгч энэ хуулийн 23а зүйлийн дагуу тайланг шалгаж, алдаа, зөрчлийг илрүүлбэл 31в зүйлд зааснаас бусад тохиолдолд алдаа зөрчлийн улмаас буруу тооцсон мөнгийг 2 дахин өсгөсөн дүнгээр төлөхийг намаас шаардах эрхтэй. Алдаа зөрчил өмч хөрөнгийн балансад, эсвэл тайлангийн тайлбар хэсэгт байр, газрын өмчтэй холбоотой, эсвэл аж ахуйн нэгжид эзэмшдэг хувьтай холбоотой гарсан бол тайлагнаагүй орхигдуулсан буюу алдаатай үнэлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцэх мөнгө төлөхийг Бундестагийн ерөнхийлөгч намаас шаардах эрхтэй. Бундестагийн ерөнхийлөгч захиргааны акт гаргаж, тухайн намд торгуулийн төлбөр хийх үүргийг ногдуулна. 31а зүйлийн 2-5-р хэсэг зохих ёсоор үйлчилнэ.

31в зүйл. Хууль бусаар олж авсан эсвэл ил болгоогүй хандив

Нам энэ хуулийн 25-р зүйлийн 2-р хэсэгт хориглосон хандивыг авч, 25-р зүйлийн 4-р хэсгийн дагуу Бундестегийн ерөнхийлөгчид шилжүүлэн өгөөгүй бол Бундестагийн ерөнхийлөгч энэ хууль бусаар авсан хандивыг 3 дахин өсгөсөн дүнгээр улсад төлөхийг намаас шаардах эрхтэй. Бундестагийн ерөнхийлөгчид өмнө нь шилжүүлсэн хандивыг төлөх торгуулийн хэмжээнээс суутгаж тооцно. Энэ хуулийн 25-р зүйлийн 3-р хэсэгт заасны дагуу нам авсан хандиваа тайланд тусгаж нийтлээгүй бол энэ орхигдуулсан хэмжээг 2 дахин өсгөсөн дүнгээр торгууль төлнө. Бундестагийн ерөнхийлөгч захиргааны акт гаргаж, тухайн намд торгуулийн төлбөр хийх үүргийг ногдуулна. 31а зүйлийн 2-5 –р хэсэг зохих ёсоор үйлчилнэ.

31-р зүйл. Эрүүгийн хариуцлагын заалтууд

- (1) Намын эд хөрөнгийн эх үүсвэр болон зарцуулалтыг нуун дарагдуулах буюу олон нийтэд тайлагнахаас зайлсхийх санаатайгаар
 1. Бундестагийн ерөнхийлөгчид хүргүүлсэн тайланд намын орлого, эд хөрөнгийн талаар буруу мэдээлэл оруулсан эсвэл буруу тайланг Бундестагийн ерөнхийлөгчид хүргүүлсэн, эсвэл
 2. хандив хүлээн авагчийн хувьд нэг хандивыг хэсэглэн бүртгэсэн буюу бүртгүүлсэн, эсвэл
 3. энэ хуулийн 25-р зүйлийн 1-р хэсгийн 3-р өгүүлбэрт заасны дагуу хандивыг шилжүүлээгүй этгээдэд гурав хүртэл жилээр хорих эсвэл мөнгөн торгууль оногдуулна. Энэ хуулийн 23б зүйлийн 2-р хэсэгт заасан нөхцөлд 23б зүйлийн 1-р хэсэгт дурдсаны дагуу өөрийн эсрэг мэдүүлэг өгсөн буюу мэдүүлэг өгөхөд оролцсон этгээдэд ял шийтгэл хүлээлгэхгүй.

- (2) Хянан шалгагч буюу түүний туслах ажилтан тайланг шалгасан үр дүнг буруу, худал мэдэгдсэн, шалгалт хийсэн тухай тайланд ноцтой нөхцөл байдлыг нуун дарагдуулсан, эсвэл хуурамч агуулгатай баталгаажуулсан тэмдэглэл үйлдсэн бол гурав хүртэл жилээр хорих ял, эсвэл мөнгөн торгууль оногдуулна. Хэрэгтэн мөнгөн урамшуулал авахын тулд, эсвэл өөрөө баяжих эсвэл бусдыг баяжуулахын тулд, эсвэл бусдыг хохироохын тулд гэмт үйдлийг хийсэн бол 5 хүртэл жилээр хорих ял, эсвэл мөнгөн торгууль оногдуулна.



ҮНДСЭН ХУУЛЬД ХАРШ НАМЫГ ХОРИГЛОХ

БҮЛЭГ

32-р зүйл. Хориглох шийдвэрийг гүйцэтгэх

- (1) Үндсэн хуулийн 21-р зүйлийн 2-р хэсэгт заасан ёсоор намыг эсвэл түүний нэг салбар байгууллагыг үндсэн хуульд харш гэж тогтоон зарлавал муж улсын засгийн газраас тохоон томилогдсон захиргааны байгууллага хууль тогтоомжийн хүрээнд үндсэн хуулийн цэцийн тогтоол, түүнтэй холбогдох заавар чиглэлийг биелүүлэх бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Муж улсын нийтийн аюулгүй байдал буюу дэг журмын асуудал хариуцсан захиргааны байгууллага дээрх зорилгоор муж улсын засгийн газрын шийдвэр, заавар чиглэлийг даган мөрдөж хэрэгжүүлнэ.
- (2) Хориглосон нам буюу түүний салбар байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагаа нэг муж улсаар хязгаарлахдахгүй тохиолдолд Холбооны улсын дотоод хэргийн сайд нам буюу салбар байгууллагыг хориглосон шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана.
- (3) Үндсэн хуулийн тухай хуулийн 35-р зүйлийн дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 болон 2-р хэсэгт зааснаас өөрөөр зохицуулж болно.
- (4) Намыг хориглосон шийдвэрийг эсэргүүцэж гомдол эсвэл сөрөг нэхэмжлэл гаргах нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зогсоох шалтгаан болохгүй. Шийдвэр гүйцэтгэхэд зарчмын ач холбогдолтой асуудлаар захиргааны

шүүхийн ажиллагаа явагдаж байгаа бол энэхүү ажиллагааг түдгэлзүүлж үндсэн хуулийн цэцээс дүгнэлт гаргуулна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад энэ ажиллагааны арга барилын талаар гаргасан гомдол, эсэргүүцлийг мөн үндсэн хуулийн цэц хэлэлцэж шийдвэрлэнэ.

- (5) Намын өмчийг хураах асуудалд 1964 оны 8-р сарын 5-нд батлагдсан Нэгдэл холбооны тухай хуулийн 10 - 13-р зүйлийг хэрэглэнэ. Хориглох шийдвэр гүйцэтгэх байгууллага нь муж улсын Засгийн газар, энэ зүйлийн 2-р хэсэгт дурдсан тохиолдолд Холбооны улсын дотоод хэргийн сайд байна.

33-р зүйл. Орлох байгууллагыг хориглох

- (1) Үндсэн хуулийн 21-р зүйлийн 2-р хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 46-р зүйлийн дагуу хориглосон намын үндсэн хуульд харш зорилго, үзэл санааг үргэлжлүүлэх байгууллагыг шинээр үүсгэн байгуулах (орлох байгууллага), эсвэл оршин тогтнож буй байгууллагыг энэ зорилгоор ашиглахыг тус тус хориглоно.
- (2) Хориглосон намыг орлох байгууллага нь өөр нам ба хориглох шийдвэр гарахаас өмнө оршин тогтнож байсан, эсвэл Бундестаг, муж улсын парламентад төлөөлөлтэй бол үндсэн хуулийн цэц тус намыг хориглосон намыг орлох байгууллага мөн болох эсэхийг тогтооно. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 38, 41, 43, 44-р зүйл, 46-р зүйлийн 3 болон энэ хуулийн 32-р зүйл зохих ёсоор үйлчилнэ.
- (3) Хориглосон намыг орлох байгууллага мөн гэж тогтоогдсон нам, эвсэл, холбоонд Нэгдэл холбооны тухай хуулийн 8-р зүйлийн 2-р өгүүлбэрийг зохих ёсоор хэрэглэнэ.



ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

БҮЛЭГ

34-р зүйл.

(Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн өөрчлөлт)

35-р зүйл.

(Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуулийн өөрчлөлт)

36-р зүйл.

(Татварын хууль тогтоомжийг хэрэглэх тухай)

37-р зүйл. Иргэний хуулийн нэг заалтыг хэрэглэхгүй байх тухай

Иргэний хуулийн 54-р зүйлийн 2-р өгүүлбэрийг намд хэрэглэхгүй.

38-р зүйл. Албадлагын хэрэгсэл

- (1) Сонгуулийн ерөнхий хорооны дарга энэ хуулийн 6-р зүйлийн 3-р хэсэгт заасан үүргийг биелүүлэхийг шаардаж намын удирдах зөвлөлд торгууль тавьж болно. Захиргааны албадлагын тухай хууль энэ тохиолдолд зохих ёсоор үйлчлэх бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооны даргыг энэ тохиолдолд албадлагыг гүйцэтгэгч байгууллагад тооцно. Торгуулийн доод хэмжээ 250 евро, дээд хэмжээ 1 500 евро байна.
- (2) Герман улсын Бундестагийн ерөнхийлөгч энэ хуулийн Тавдугаар бүлгийн шаардлагыг хангасан тооцооны тайланг ирүүлэхийг шаардаж намын удирдах зөвлөлд торгууль тавьж болно. Захиргааны албадлагын тухай хууль энэ тохиолдолд зохих ёсоор үйлчилнэ. Герман улсын Бундестагийн

ерөнхийлөгчийг энэ тохиолдолд албадлагыг гүйцэтгэгч байгууллагад тооцно. Торгуулийн доод хэмжээ 500 евро, дээд хэмжээ 10 000 евро байна.

39-р зүйл. Төгсгөл болон шилжилтийн зохицуулалт

- (1) 1994 оны 1-р сарын 1-нээс өмнө хүчинтэй байсан энэ хуулийн 22-р зүйлийн 1-р өгүүлбэрийг үндэслэн баталсан мужулсуудын хууль тогтоомжийн заалтууд хүчингүй болсон.
- (2) 2003 болон 2004 оны төрийн санхүүжилт болон харьцангуй дээд хязгаарыг 18-р зүйлийн 3-р хэсгийн 3 дагуу тогтооход намын тайланд хавсаргах хандивын мэдээллийг 2002 оны 12-р сарын 31 хүртэл үйлчлэх хуулийн 24-р зүйлийн 2-р хэсгийн 1 ба 2-д заасан журмаар гаргана. Энэ заалт мөн 2002 оны тооцоо тайлан гаргахад үйлчилнэ.
- (3) Энэ хуулийн 23а зүйлийн 3-р хэсэг 2002 оноос эхлэх намын тайлангийн хянан шалгалтанд үйлчилнэ. 2003 оны тайланг энэ хуулийн 2004 оны 1-р сарын 1-ээс эхлэн хүчинтэй болох найруулгын 24, 26, 26а, 28-р зүйлийн дагуу гаргаж болно.
- (4) Энэ хуулийн 28-р зүйлийн 2-р хэсгийг анх хэрэгжүүлэх зорилгоор эд хөрөнгийн зүйл худалдан авах, үйлдвэрлэх өртгийг тооцож гаргахад маш их зардал болон цаг зарцуулахаар байвал намын 2002 оны тайлангийн эд хөрөнгийн дансны бүртгэлээс хуулбарлан бүртгэж болно. Энэ хуулийн 28-р зүйлийн 2-р хэсгийн дагуу төлөвлөгөөт элэгдэл, хорогдол тооцохгүй эд хөрөнгийн зүйлийн өртгийг Аж ахуй эрхлэх тухай хууль тогтоомжийг чанд баримтлан тогтоосон бол 2002 оны тайлангаас хуулбарлан бүртгэж болно. Энэ тухай тайланд хавсаргах тайлбар хэсэгт тэмдэглэнэ.
- (5) 2016 оны тайлант жилээс эхлэн 2-р зүйлийн 2-р хэсгийн 2-р өгүүлбэрийг 19а зүйлийн 3-р хэсгийн 1 ба 2-р өгүүлбэрт заасан хугацаанд ирүүлэх тайланд хэрэглэнэ. 2015 оны тайлант жилээс эхлэн 190-р зүйлийн 4-р хэсгийн 2-р өгүүлбэрийг 19а зүйлийн 3-р хэсгийн 1 ба 2-р өгүүлбэрт заасан хугацаанд ирүүлэх тайланд хэрэглэнэ. 25-р зүйлийн 3-р хэсгийн 1-р өгүүлбэрийн дагуу 2015 оны тайланд нийт хандивын дүнг тооцон гаргахад 2015 оны 12-р сарын 31 хүртэл хүчинтэй найруулгын 25-р зүйлийн 3-р хэсгийн 1-р өгүүлбэрт заасан хандивуудыг үндэс болгоно.

40-р зүйл.

(Хүчингүй болсон)

41-р зүйл.

(Хүчин төгөлдөр болох)



Монгол дахь Конрад-Аденауэр-Сан
Сөүлийн гудамж Браухаус 22
Улаанбаатар хот 14253
Монгол улс

www.kas.mongolia
www.facebook.com/kas.mongolia
www.kas.edu.mn